

Түүнийг биднийг Бүтээгч Эзэн хэмээн амаараа хүлээн зөвшөөрч зүрхэндээ итгэж авралын замаар хамтдаа алхцгаая! Амьдрал хэдий богинохон ч амжиж Түүнд итгэж чадваас мөнхийн улсад очих хаалга таны өмнө нээлттэй... Иоган 14:16д..." Би бол Зам, Үнэн, Амь мөн: Хэн ч Надаар дамжихгүйгээр Эцэгт хүрч чадахгүй." гэсэн. Бурханы өмнө гэм нүглээ улайн Есүс Христийг өөрийн Аврагч Эзэн гэж хүлээн авахыг хүсэж байна уу ? Та чин сэтгэлээсээ залбиран сайн мэдээний дагуу гэм нүглээ уучлуулахыг хүсэж байна уу ? Өөр зам, өөр найдвар байхгүй тул та өнөөдөр Есүст итгэн Түүнийг хүлээн авна уу.



P.O. BOX 609 • YORK, SC 29745 • 803-684-1535
WWW.HOPETRACTS.ORG
What Is The Gospel? Tract 645

Сайн Мэдээ гэж юу вэ?



“Сайн мэдээ”энэ үгийг та лавтайяа нэг бус удаа сонсож байсан гэдэгт би эргэлзэхгүй байна.Жишээ нь: Тань руу найз чинь залгаад “Өө найз нь чамд дуулгах сайн мэдээтэй шүү” гэх мэтчилэн бид энэ үгийг маш түгээмэл хэрэглэдэг.Тэгвэл өнөөдөр чухам юуг “сайн мэдээ” гэж нэрлэж буй талаар Ариун судар болох Библи дээр үндэслэн тайлбарлахыг зорьлоо.Энэ тухай Паул бидэнд тодорхой тайлбарласан юм.Үүнд:**Судрын дагуу Христ бидний төлөө үхсэн бөгөөд оршуулагдсан тэрээр сударт бичигдсэнчлэн 3 дахь өдөртөө амилуулагджээ.1Коринт15:1-4** Товчихондоо үүнийг л бид Есүс Христийн тухай “сайн мэдээ”гэж байгаа юм.

Магадгүй та “Яагаад үүнийг сайн мэдээ гэж?” хэмээн эргэлзэж болох юм.Таны зөв! Учир нь сайн мэдээ нь муу мэдээнээс гаралтай.Тэгвэл муу мэдээ нь гэвээс Бурхан бидэнд хандан: Та нар бүгд гэм нүгэлтэй хэмээн нүцгэн үнэнийг хэлсэн. **Ром3:24т “Бүгд нүгэл үйлдсэнээр Бурханы алдарт хүрдэггүй”** гэжээ.Учир нь Бурхан бол төгс.

Хүүхэд байхдаа бид хэнээр ч заалгалгүйгээр сахилгагүйтэж бас худал хэлдэг. Энэ нь төрөлх зан юм.Үүнийхээ төлөө бид шийтгүүлж, загнуулан байж зөвийг үйлдэхэд суралцдаг.Энэ нь бид эхээс төрөхдөө л гэмт чанарыг өвлөсөн болохыг гэрчилж байна. Бид бүгд ямар нэгэн байдлаар гэм нүгэл үйлдсэн. Тухайн гэм нүглийг хэдий чинээ удаан хийнэ төдий чинээ түүндээ хүлэгддэг. Зарим хүн хорих газар орж байгаагүй ба цэвэр ёс суртахуунтай амьдарч ирсэн ч “**бүгд нүгэл үйлдсэн тул Бурханы алдарт хүрдэггүй**”. Библи дээр **Зөвт хүн алга,ганц ч алга . Ром 3:10** хэмээжээ. Гэсэн хэдий ч Исай 64:6 д **“бидний бүх зөв үйлс нь бохир**

хувцас мэт байдаг.” гэж тодорхой хэлсэн. Хорих газар орж байгаагүй юм уу эсвэл бурууг хийгээд баригдаагүй учраас махан биеийн үхлийн дараа сүнс нь Мөнхийн Улсад очно гэсэн үг биш. Чухам үнэндээ хамгийн сайн хүн ч амьдралдаа буруу мууг үйлдсэн л байдаг. **Иаков 2:10д “Учир нь бүх хуулийг сахивч нэг дээр нь бүдрэх хэн боловч бүх хуулийг зөрчсөн болно”**.гэсэн.Иймээс та бид бүгд адилхан тул Бурханы алдарт хүрч чадахгүй. Энэ л биднийг Сайн Мэдээ рүү хөтөлж байна.

Бурхан бидэнд хайртай.Тиймээс Өөрийн Цорын Ганц Хүү болох Есүсийг та бидний гэм нүглийн төлөөс болгон энэ дэлхийд илгээсэн юм.(Хэн нэгэн мэдвэл ичгүүртэй тийм гэм нүглээ бод доо.) Тэр нүглийн чинь шийтгэлийг Есүс үүрсэн юм.Түүний урсгасан цус бидэнд Бурханы мэлмийд зөвт байдлыг олох хаалгыг нээж өгсөн билээ. **“Учир нь Христ нэг удаа нүглийн төлөө үхэж,зөвт нь зөвт бусыг орлосон. Энэ нь биднийг Бурханд аваачихын тулд болой”1Петр3:18.**

Бурханы өмнө гэмшин гэмт амьдралаас эргэх нь бидний Эзэн Есүс Христэд итгэх итгэл мөн.1Петр2:24д **“Биднийг нүгэлд үхүүлж, зөвт байдалд амьдруулахын тулд Тэр Өөрөө бидний нүглийг модон дээр биеэрээ үүрсэн. Учир нь та нар Түүний шархаар эдгээгдсэн билээ.”** 2Коринт5:21д **” Тэр нүглийг үл мэдэгч Түүнийг бидний төлөө нүгэл болгосон юм.Тэгснээр бид Түүний дотор Бурханы хүртээх зөвт байдал болох юм.”**

Ахан дүүсээ Бурханы өмнө өөрийн гэм нүглийг улайж (**Үйлс 20:21**), бүтээлийг бус харин Бүтээгч Эзэнд талархаж амьдаръя.